



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар A/1110

Улаанбаатар хот

Маягтын загвар, журам
шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10 дахь заалт, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:


1.“Барьцаалбар /ЭУБ-16 маягт/-ыг 1 дүгээр хавсралтаар, “Барьцаалбарын барьцаа, давхар барьцаа, барьцаалбарын шилжүүлэг /ЭУБ-17 маягт/-ийг 2 дугаар хавсралтаар, “Барьцаалбарт өөрчлөлт оруулах, тэмдэглэл хийх /ЭУБ-18 маягт/-ыг 3 дугаар хавсралтаар, барьцаалбар үйлдсэн үл хөдлөх эд хөрөнгийн давхар барьцаа /ЭУБ-19 маягт/-г 4 дүгээр хавсралтаар, “Үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах тухай мэдэгдэл /ЭУБ-20 маягт/-ийг 5 дугаар хавсралтаар, “Үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах тухай мэдэгдэл хүргүүлэх нийтлэг журам”-ыг 6 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын 2014 оны 1125 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар /Б.Ариунболд/-т даалгасугай.

ДАРГА

Д.ДЭЛГЭРСАЙХАН



142400784

Улсын бүртгэлийн ерөнхий газрын
даргын **24** санын **06** дугаар сарын **26**-ны
өдрийн **11:00** дугаар тушаалын
1-р хавсралт

ЭУБ-16 маягт

БАРЬЦААЛБАР №

1	Барьцааны талуудын талаарх мэдээлэл	Барьцаалулагч	Барьцаалагч	Барьцаалулагч 8266216 ГСТ609 нь гуравдагч этгээд бол үндсэн үүргийн үүрэг гүйцэтгэгч	
	Иргэн бол: Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа газар. Хуулийн этгээд бол: Нэр, регистр, хувийн хэргийн дугаар, оршин байгаа газар.				
2	Барьцааны эрх үүссэн үндэслэл, огноо, газар				
3	Барьцаагаар хангагдах үүргийн болон хүүгийн хэмжээ, тэдгээрийг тодорхойлох арга				
4	Барьцаагаар хангагдах үүргийг хугацаанаас нь өмнө гүйцэтгэж болох эсэх <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> угүй <input type="checkbox"/>				
5	Барьцааны зүйлийн талаарх мэдээлэл	Барьцааны зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн нэр	Эрхийн улсын бүртгэлийн дугаар	Байршил /албан ёсны хаяг/	Барьцааны зүйлийн шинж байдлын тодорхойлолт /зориулалт, талбайн хэмжээ, бусад/
6	Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрх барьцаалсан бол	Эрхийн улсын бүртгэлийн дугаар, байршил, албан ёсны хаяг	Үл хөдлөх эд хөрөнгийн шинж байдлын тодорхойлолт	Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрх эзэмшигчийн талаарх мэдээлэл	Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрх үүссэн үндэслэл Уг эрхийн хүчинтэй байх хугацаа
7	Барьцааны зүйлтэй холбоотой гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх байгаа эсэх тухай	Байхгүй: <input type="checkbox"/>	Байгаа бол:		
8	Энэхүү барьцаалбарын хууль ёсны эзэмшигч нь түүнийг бусдад шилжүүлж болно гэдгийг Барьцаалулагч зөвшөөрч байна.				
9	Барьцааны зүйлээс шаардлагыг хангах журам				
10	Талуудын харилцан тохиролцсон бусад нөхцөл				
11	Барьцаалбар үйлдсэн:	Барьцаалулагч иргэн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, гарын үсэг; Хуулийн этгээд бол түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн албан тушаал эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, гарын үсэг, тамга тэмдэг /Цахим хэлбэрээр илгээсэн тохиолдолд тоон гарын үсэг, цахим тамга/	Барьцаалулагч нь гуравдагч этгээд /барьцаагаар хангагдсан үүргийн үүрэг гүйцэтгэгч/ иргэн бол эцэг, /эх/-ийн нэр, өөрийн нэр, гарын үсэг; Хуулийн этгээд бол түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн албан тушаал, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, гарын үсэг, тамга тэмдэг /Цахим хэлбэрээр илгээсэн тохиолдолд тоон гарын үсэг, цахим тамга/		
	Барьцаалбар үйлдсэн огноо				
12	Гэрээ байгуулсан огноо, газар	Барьцаалбарыг бүртгэсэн огноо	Улсын бүртгэгчийн эцэг/эхийн нэр, өөрийн нэр	Гарын үсэг, хувийн тэмдэг /цахим хэлбэрээр илгээсэн тохиолдолд тоон гарын үсэг/	

Энэ хэсгийг улсын бүртгэлийн байгууллага бөглөнө.

Улсын бүртгэлийн өрөхийг тазрын
даргын 2021 оны 06 дугаар сарын 25-ны
өдрийн 11:00 дугаар тушаалын
2-р хавсралт

ЭУБ-17 маягт

БАРЬЦААЛБАРЫН БАРЬЦАА, ДАВХАР БАРЬЦАА, ШИЛЖҮҮЛЭГ

Барьцаалбарыг барьцаалах, давхар барьцаалах, барьцаалбарыг шилжүүлэхэд энэхүү **маягтыг үзүүлэх** бөгөөд барьцаалбарын эх хувийн хамт хүчин төгөлдөр болно.

1	БАРЬЦААЛБАРЫГ БАРЬЦААЛАХ	БАРЬЦААЛБАРЫГ ДАВХАР БАРЬЦААЛАХ	БАРЬЦААЛБАРЫН ШИЛЖҮҮЛЭГ		
			<input type="checkbox"/> худалдах	<input type="checkbox"/> барьцаалах	
2	Барьцаалбарын дугаар:		xxxxxxxxxx		
	Барьцаалбарын давхар барьцааны дугаар:		xxxxxxxxxx-01		
	Барьцаалбарын шилжүүлгийн дугаар:		xxxxxxxxxx-02		
3	Барьцаалбарыг барьцаалсан, давхар барьцаалсан, шинээр эрх олж авсан этгээдийн талаарх мэдээлэл:				
	Хуулийн этгээдийн нэр	Хуулийн этгээдийн регистр, хувийн хэргийн дугаар, оршин байгаа хаяг	Оршин байгаа хаяг		
4	Барьцаалбарыг барьцаалуулсан, давхар барьцаалуулсан, барьцаалбар шилжүүлж буй барьцаалагч этгээдийн талаарх мэдээлэл:				
	Хуулийн этгээдийн нэр, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн албан тушаал, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр	Хуулийн этгээдийн регистр, хувийн хэргийн дугаар, оршин байгаа хаяг	Төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга, тэмдэг /цахим хэлбэрээр ирүүлсэн тохиолдолд тоон гарын үсэг/ /барьцаалагч гарын үсэг зурах бөгөөд барьцаалбарын бичилт нь анхных биш бол өмнөх бичилтэд заасан барьцаалбар эзэмшигч гарын үсэг зурна/		
5	Барьцаалбарыг барьцаалсан тэмдэглэгээ, барьцаалбарын шилжүүлэг хийгдсэн үндэслэл:				
	Барьцаалбарыг барьцаалсан, давхар барьцаалсан бол энэ талаар тэмдэглэгээ хийх.				
	Барьцаалбарыг шилжүүлсэн бол эрх шилжүүлсэн үндэслэлийн талаар бичилт хийх, Ул хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу мэдэгдсэн эсэх талаар бичих				
6	Барьцаалбарыг өмнө нь барьцаалсан бол өмнөх барьцааны талаарх мэдээлэл:				
	Өмнөх барьцаалагч хуулийн этгээдийн нэр, регистр, хувийн хэргийн дугаар	Барьцаалбарыг өмнө нь барьцаалсан тухай гэрээний огноо, барьцаалагчийн талаарх мэдээлэл, уг барьцаалбарын хууль ёсны эзэмшигчийн ямар хэмжээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор уг гэрээг байгуулсан талаарх мэдээлэл. (Өмнө нь нэг буюу түүнээс дээш удаа барьцаалуулсан бол өмнөх барьцаа үүссэн дарааллаар)			
7	Барьцаалбарын дараачийн барьцааны талаарх мэдээлэл:				
	Дараачийн барьцаалагч хуулийн этгээдийн нэр, регистр, хувийн хэргийн дугаар	Анхны барьцаалагчаас хойш тухайн барьцаалбарыг давхар барьцаалсан тухайн гэрээний огноо, дараагийн барьцаалагчийн талаарх мэдээлэл, уг барьцаалбарын хууль ёсны эзэмшигчийн ямар хэмжээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор уг гэрээг байгуулсан талаарх мэдээлэл. (Өмнө нь нэг буюу түүнээс дээш удаа давхар барьцаалуулсан бол дараачийн барьцаа үүссэн дарааллаар)			
8	Барьцаалбарыг шилжүүлсэн тохиолдолд уг маягтыг нотариатаар гэрчлүүлэх бөгөөд энэ хэсгийг нотариат бөглөнө.				
	Гэрчилсэн огноо	Нотариатчийн эцэг/эхийн нэр, өөрийн нэр	Гарын үсэг, хувийн тэмдэг /цахим хэлбэрээр илгээсэн тохиолдолд тоон гарын үсэг/		
9	Энэ хэсгийг улсын бүртгэлийн байгууллага бөглөнө.				
	Барьцаалбарын барьцааг бүртгэсэн огноо	Улсын бүртгэгчийн эцэг/эхийн нэр, өөрийн нэр	Гарын үсэг, хувийн тэмдэг /цахим хэлбэрээр илгээсэн тохиолдолд тоон гарын үсэг/		

Улсын бүртгэлийн ерөнхий газрын
даргын ~~2021~~ оны ~~06~~ дугаар сарын ~~26~~-ны
өдрийн ~~11~~ дугаар тушаалын
3-р хавсралт

ЭУБ-18 маягт

БАРЬЦААЛБАРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ТЭМДЭГЛЭЛ ХИЙХ

Энэхүү маягт нь Ул хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т заасны дагуу барьцаалбарын эх хувьд хавсаргах бөгөөд тухайн барьцаалбарын салшгүй хэсэг болно.

1	Барьцаалбарын дугаар:	xxxxxxxxxx
	Барьцаалбарын өөрчлөлтийн дугаар:	xxxxxxxxxx-01
2	Эрхийн улсын бүртгэлийн дугаар:	
3	Барьцаалбарт өөрчлөлт оруулсан огноо:	
4	Барьцаалбарт оруулсан өөрчлөлтийн агуулга:	
5	Барьцаагаар хангагдах үүргийг хэсэгчлэн эсхүл бүрэн гүйцэтгэсэн тухай тэмдэглэл	Барьцаагаар хангагдах үүргийг хэсэгчлэн эсхүл бүрэн гүйцэтгэсэн огноо
6	Барьцаалбарт өөрчлөлт оруулсан, тэмдэглэл үйлдсэн :	
	Талууд:	Үүрэг гүйцэтгэгч
	Иргэн бол: Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар; Хуулийн этгээд бол: Нэр, хувийн хэргийн дугаар, төлөөлөх эрх бүхий этгээдийн албан тушаал, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр	
	Гарын үсэг, хуулийн этгээд бол тамга, тэмдэг /цахим хэлбэрээр илгээсэн тохиолдолд тоон гарын үсэг, цахим тамга/	
7	Энэ хэсгийг улсын бүртгэлийн байгууллага бөглөнө.	
	Өөрчлөлтийг бүртгэсэн огноо	Улсын бүртгэгчийн эцэг/эхийн нэр, өөрийн нэр
		Гарын үсэг, хувийн тэмдэг /цахим хэлбэрээр илгээсэн тохиолдолд тоон гарын үсэг/

Улсын бүртгэлийн өрөнхий газрын
даргын ~~2020~~ оны 06 дугаар сарын ~~26~~ ны
өдрийн ~~Анхны~~ дугаар тушаалын
4-р хавсралт

ЭУБ-19 маягт

БАРЬЦААЛБАР ҮЙЛДСЭН ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН ДАВХАР БАРЬЦАА

1	Анхны болон өмнөх барьцаалбарын дугаар:	xxxxxxxxxx		
	Барьцаалбарын давхар барьцааны дугаар:	xxxxxxxxxxx-01		
2	Барьцаалбарын давхар барьцааны огноо			
3	Барьцаалбар үйлдсэн үл хөдлөх эд хөрөнгийг давхар барьцаалсан этгээдийн талаарх мэдээлэл:			
	Хуулийн этгээдийн нэр	Хуулийн этгээдийн регистр, хувийн хэргийн дугаар		
		Оршин байгаа хаяг		
4	Барьцаалбар үйлдсэн үл хөдлөх эд хөрөнгийг давхар барьцаалуулсан этгээдийн талаарх мэдээлэл:			
	Иргэн бол: Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа газар, гарын үсэг, Хуулийн этгээд бол: Нэр, регистр, хувийн хэргийн дугаар, оршин байгаа газар, эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдэг.			
5	Барьцааны зүйлийн талаарх мэдээлэл:			
	Барьцааны зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн нэр	Эрхийн улсын бүртгэлийн дугаар	Байршил /албан ёсны хаяг/	Барьцааны зүйлийн шинж байдлын тодорхойлолт /огноо, зориулалт, талбайн хэмжээ, бусад/
6	Барьцаалбар үйлдсэн үл хөдлөх эд хөрөнгийг давхар барьцаалсан тэмдэглэгээ:			
7	Барьцаалбар үйлдсэн үл хөдлөх эд хөрөнгийг өмнө нь барьцаалуулсан бол өмнөх барьцааны талаарх мэдээлэл:			
	Өмнөх барьцаалагч хуулийн этгээдийн нэр, регистр, хувийн хэргийн дугаар	Барьцаалбар үйлдсэн үл хөдлөх эд хөрөнгийг өмнө нь барьцаалсан тухай гэрээний огноо, барьцаалагчийн талаарх мэдээлэл, уг барьцаалбарын хууль ёсны эзэмшигчийн ямар хэмжээний үргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор уг гэрээг байгуулсан талаарх мэдээлэл. (өмнө нь нэг буюу түүнээс дээш удаа барьцаалуулсан бол өмнөх барьцаа үүссэн дарааллаар)		
8	Барьцаалбар үйлдсэн үл хөдлөх эд хөрөнгийг дараачийн барьцааны талаарх мэдээлэл:			
	Дараачийн барьцаалагч хуулийн этгээдийн нэр, регистр, хувийн хэргийн дугаар	Энэ маягтын 2-т бичигдсэн барьцаалагчаас хойш тухайн Барьцаалбар үйлдсэн үл хөдлөх эд хөрөнгийг давхар барьцаалсан тухай гэрээний огноо, дараачийн барьцаалагчийн талаарх мэдээлэл, уг барьцааны зүйлийн өмчлөгчийн ямар хэмжээний үргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор уг гэрээг байгуулсан талаарх мэдээлэл. (Энэ хавсралтын 2-т бичигдсэн барьцаалагчаас хойш нэг буюу түүнээс дээш удаа давхар барьцаалуулсан бол дараачийн барьцаа үүссэн дарааллаар)		
9	Энэ хэсгийг улсын бүртгэлийн байгууллага бөглөнө.			
	Барьцаалбар үйлдсэн үл хөдлөх эд хөрөнгийг давхар барьцааг бүртгэсэн огноо	Улсын бүртгэгчийн эцэг/эхийн нэр, өөрийн нэр	Гарын үсэг, хувийн тэмдэг /цахим хэлбэрээр илгээсэн тохиолдолд тоон гарын үсэг/	

Улсын бүртгэлийн ерөнхий газрын
даргын **2021** оны **06** дугаар сарын **28**-ны
өдрийн **11:10** дугаар тушаалын
5-р хавсралт

ЭУБ-20 маягт

**ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ БАРЬЦААНЫ ЗҮЙЛЭЭС
ХАНГУУЛАХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ**

Мэдэгдэл үйлдсэн огноо /......./

Үүрэг гүйцэтгэгч, барьцаалуулагч, тухайн барьцааны зүйлтэй холбоотой эрхээ бүртгүүлсэн гуравдагч этгээд (аль нь болохыг доогуур зурах)
(иргэний бүртгэлийн дугаар, хуулийн этгээд бол регистр, хувийн хэргийн дугаар) дугаартай

(Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол нэр, төлөөлөх эрх бүхий этгээдийн албан тушаал, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр)

Танд үүргээ гүйцэтгэхийг шаардах мэдэгдлийг оны сарын -ны өдөр хүргүүлсэн бөгөөд мэдэгдэлд заасан хугацаанд үүргээ биелүүлээгүй, хариу ирүүлээгүй тул Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2, 42.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж барьцаалуулагч болон барьцааны зүйлтэй холбоотой эрхээ бүртгүүлсэн гуравдагч этгээдэд үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах, барьцааны зүйлийг худалдах ажиллагааг эхлүүлэхийг МЭДЭГДЭЖ БАЙНА.

Мэдэгдэл хүлээн авагчийн мэдээлэл:			
Мэдэгдэл хүлээн авагч	Иргэн бол: Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар. Хуулийн этгээд бол: нэр, регистр, хувийн хэргийн дугаар.	Оршин суугаа/байгаа хаяг	Утасны дугаар, цахим шуудангийн хаяг
Үүрэг гүйцэтгэгч, барьцаалуулагч			
Барьцааны зүйлтэй холбоотой эрхээ бүртгүүлсэн гуравдагч этгээд			
Мэдэгдэл үйлдсэн барьцаалагчийн мэдээлэл:			
Барьцаалагчийн нэр	Хуулийн этгээдийн регистр, хувийн хэргийн дугаар	Оршин байгаа хаяг	Төлөөлөх эрх бүхий этгээдийн албан тушаал, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, гарын үсэг, тамга, тэмдэг
Энэ хэсгийг улсын бүртгэлийн байгууллага бөглөнө.			
Мэдэгдлийг бүртгэсэн огноо	Улсын бүртгэгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр	Гарын үсэг, хувийн тэмдэг /цахим хэлбэрээр илгээсэн тохиолдолд тоон гарын үсэг/	

Улсын бүртгэлийн өрөнхий газрын
даргын ~~2021~~ хоны 6 дугаар сарын ~~28~~-ны
өдрийн ~~2021~~ дугаар тушаалын
6-р хавсралт

ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ БАРЬЦААНЫ ЗҮЙЛЭЭС
ХАНГУУЛАХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ НИЙТЛЭГ ЖУРАМ

1. Барьцаалагч нь үүрэг гүйцэтгэгч, барьцаалуулагч, тухайн барьцааны зүйлтэй холбоотой эрхээ бүртгүүлсэн гуравдагч этгээдэд Иргэний хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах тухай мэдэгдэл (цаашид “мэдэгдэл” гэх)-ийг хүргүүлэхдээ энэхүү журмыг баримтална.

2. Барьцаалагч нь мэдэгдлийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар баталсан маягтын дагуу үйлдэж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, үүрэг гүйцэтгэгч, барьцаалуулагч, тухайн барьцааны зүйлтэй холбоотой эрхээ бүртгүүлсэн гуравдагч этгээдэд хүргүүлнэ.

3. Мэдэгдлийг үүрэг гүйцэтгэгч, барьцаалуулагч, тухайн барьцааны зүйлтэй холбоотой эрхээ бүртгүүлсэн гуравдагч этгээд тус бүрд шууд хүргүүлэх бөгөөд хүргүүлэх хэлбэр, хүргүүлсэн гэж үзэх, нотлох зэргийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд барьцаалагч шийдвэрлэнэ.

4. Үүрэг гүйцэтгэгч, барьцаалуулагч, тухайн барьцааны зүйлтэй холбоотой эрхээ бүртгүүлсэн гуравдагч этгээд нь барьцаалагчид бүртгүүлсэн утасны дугаар, цахим шуудангийн хаяг, оршин суугаа хаяг зэргээ өөрчилсөн тохиолдолд энэ тухай барьцаалагчид мэдэгдэх үүрэгтэй.

5. Дээрх мэдээллийдээ өөрчилснөө мэдэгдээгүй үүрэг гүйцэтгэгч, барьцаалуулагч, тухайн барьцааны зүйлтэй холбоотой эрхээ бүртгүүлсэн гуравдагч этгээдэд мэдэгдлийг хүргүүлэх арга хэлбэрийг барьцаалагч сонгон шийдвэрлэнэ.

6. Барьцааны зүйлийг давхар барьцаалсан тохиолдолд барьцаалагч нь энэхүү мэдэгдлийг хүргүүлэхийн өмнө бүх өмнөх болон дараачийн барьцаалагч нарт, барьцаалуулагч нь гуравдагч этгээд бол үүрэг гүйцэтгэгчид, барьцааны зүйл нь түрээсийн зүйл зэрэг тухайн барьцааны зүйлтэй холбоотой эрхээ бүртгүүлсэн гуравдагч этгээдэд энэ тухай урьдчилан мэдэгдсэн байх үүрэгтэй.

—_оOo_—